

МОНГОЛ ДАХЬ ОРОН НУТГИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ

М.Жавзансүрэн докторант

МУИС, НШУС, Түүхийн тэнхим

Улс төрийн шинжлэх ухаанд илүүтэй хамаарагдах, нарийн төвөгтэй, маргаантай, төрийн удирдагчид хийгээд ард түмнийг “хөдөлгөж” чаддаг нь төрийн сонгуулийн тухай ойлголт юм. Нэн ялангуяа ард түмэн эрт цагаас сайн сайхан нийгэм байгуулахыг мөрөөдөж, тэмцээр ирсэн бөгөөд үр дүн нь тийм ч таатай бус байсаар ирсэн юм. Тиймдээ ч сонгуулийн идэвх, оролцоо өндөр байсаар ирсэн. Өнгөрсөн тогтолцооны үеүүдэд “ардчилсан” сонгуулийн тухай ойлголт бүрхэг байсан ч гэсэн тухайн нийгмийн онцлогоос шалтгаалан 99-100% нь сонгуульд оролцож, 99-100 % ийн саналаар сонгогдож байв. Харин 1990 оноос хойш сонгуулийн тогтолцоо ардчилсан шинжийг өөртөө агуулж, сонгох, сонгогдох эрх нээлттэй болсон хэдий ч мөн л маргаан мэтгэлцээн дагуулсаар буй юм. Тэгвэл бид энэ удаагийнхаа өгүүлэлд өнөөгийн ардчилсан сонгуулийн эх үүсвэр хэрхэн тавигдаж хөгжлийн мөн чанарыг олж эдүгээ хүрсэнийг тодруулан судлахыг зорьж буй юм.

Сонгуулийн тогтолцооны үзэл баримтлал, зарчим, онцлог шинж нь тухайн улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн дэглэм, төр ёсны түүхэн уламжлалаас шалтгаалдаг. Сонгуулийн тогтолцоо, түүний хэрхэн бүрэлдэн төлөвшсөн тухайд Монголын болон гадаадын эрдэмтэд судлаачид нилээдгүй судалгаа хийжээ. Үүнд: И.Дашням,¹²⁸ И.Я.Златкин,¹²⁹ Г.С. Матвеева,¹³⁰ М.Санждорж,¹³¹ Л.Тойв¹³² нарыг нэрлэж болох юм. Дээрх эрдэмтэд 1921 онд Монгол оронд “сонгуулийн цоо шинэ тогтолцоо” бий болсон хэмээн үзсэн бөгөөд сонгуулийн тогтолцооны үүсэл, хөгжлийг үндсэнд нь 1921-1940 он, 1940-1960 он, 1960 оноос хойших хэмээн 3 хуваан авч үзжээ.

“Монголын үнэн” сонины 1920 оны XI.10-ны дугаарт “Гадна, дотны мөлжих дарлах зүйлүүдийг шүүрдэн арилгаж, улс төрийн эрх мэдлийг ард олон өөрснөө эзлэн авч, чухам итгэлтэй үнэнхүү санаанаас олны тусыг хичээх хэрэг үйлсээ явуулан чадах шударга эрдэмтэй сайн хүн нарыг ард өөрснөө сонгож улсын засаг бариулна”¹³³ хэмээгээд “21 насанд хүрсэн иргэд бүгдээрээ цуглан хуралдаж, **сумын хурлыг** байгуулаад, цааш цааш нь дээд шатны хурлыг шат дамжуулан сонгож байгуулах”¹³⁴ тухай зааж өгсөн явдал нь орон нутгийн эрх барих байгууллагын сонгуулийн түүхийн эхлэл болж байв.

1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын дараах түүхэн үйл явцын нэг нь засгийн бүх эрхийг ард түмний гарт өгөх зорилт байсан бөгөөд үүнийг шийдэх эхний арга хэмжээ нь орон нутгийн засаг захиргааны асуудлыг цэгцэлж, ардын төлөөлөгчдийн байгууллагын эх үүсвэр болох **хурлыг** байгуулах явдал байсан юм.

¹²⁸ Дашням.И. БНМАУ-ын сонгуулийн систем.УБ.1975

¹²⁹ Златкин.И.Я. Очерки новой и новейшей истории Монголии.М. 1957

¹³⁰ Матвеева.Г.С. Старицина.П.П. Народная демократий строительство социализма в МНР.М.1965

¹³¹ Санждорж.М. Ардын төрийн түүх. УБ. 1974

¹³² Тойв.Л. БНМАУ-ын сонгуулийн систем. УБ.1950

¹³³ МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд.1920-1940.УБ.1966.17 тал

¹³⁴ Мөн тэнд. тал 24

Ардын засгийн эхний жилүүдэд хувьсгалын өмнөх засаг захиргааны зохион байгуулалт үндсэндээ өөрчлөгдөж, цаашид улам боловсронгуй болсоор байсан юм. Үүнийг доктор М.Санждорж:

- Засаг захиргааны зохион байгуулалтыг үндсээр нь өөрчилсөн үе (1921-1931)
- Засаг захиргааны зохион байгуулалт тус улсын хөгжлийн хэр хэмжээ, шаардлагад тохирон хөгжингүй боловсронгуй болж ирсэн үе (1931 оноос хойш)¹³⁵ хэмээн хоёр хуваасан байдаг.

1921 оны IX сарын 5-нд нийслэл Хүрээнд байнга зөвлөлдөх байгууллага болох улсын түр цагийн хурал байгуулагдаж, түүний бүрэлдэхүүнд аймаг, шавь бүрээс таван ард, нижгээд язгууртан төлөөлөгч, мөн цэрэг НТХ (Намын төв хороо), ХЗЭ-ийн (Хувьсгалт Залуучуудын Эвлэл) хорооноос зохих тооны төлөөлөгч оролцуулахаар шийдвэрлэжээ. Тэрчлэн дээрх хурал шиг төлөөлөгчдийн байгууллага аймаг, хошуудад байгуулагдсаар байв. Энэхүү **түр цагийн хурал нь** АДХ-ын эх үүсвэр байсан¹³⁶ хэмээн үзсэн байдаг. Түр цагийн хуралд хожмын АДХ-ын үйл ажиллагааны зарчим тодорхой хэмжээгээр тусгагдсан учир агуулгаараа үндсэн хуулийн ач холбогдолтой баримт бичиг байсан юм.

Орон нутгийн засаг захиргааг өөрчлөх асуудал үндсэндээ 1923-1924 он хүртэл үргэлжилсэн ба баг, сумуудын хурлаар цаашид тавих зорилтоо тодорхойлж өгсөн байна.

1923-1925 онд “Монголын олон засаг ба засаг бус ван, гүнгүүдийн эрх хэмжээний дүрэм” (1922)¹³⁷, “Монгол улсын нутгийн захиргааны дүрэм”(1923)¹³⁸, “Их шавийн захиргааны дүрэм”(1923)¹³⁹, “Ховдын харъяат газрын захиргааны дүрэм” (1924), “Дарьгангын нутгийн захиргааны дүрэм”, “Улаанбаатар хотын захиргааны газрын дагаж явах дүрэм”¹⁴⁰ зэргийг баталсан. Эдгээр дүрмийг үндэслэн засаг захиргааны байгууллага байгуулах ажил өрнөсөн бөгөөд үүний үр дүнд **арван, гэр, хошуу, сум, багаас хурал** байгуулжээ.

“Нутгийн захиргааны дүрэм” ёсоор арван гэрийн хурлууд бий болж, засаг захиргааны удирдлагад байгаа засаг ноёдыг ардын төлөөлөгчөөр сольсон явдлыг доктор М.Санждорж “... ард олны үндсэн ашиг сонирхлын асуудлууд хэлэлцэн нутгийн захиргааны эрх баригчдыг сонгосон нь тус орны түүхэнд урьд өмнө үзэгдээгүй улс төрийн гүн гүнзгий ач холбогдолтой цоо шинэ үзэгдэл байв” хэмээгээд “... Монголд төрийн эрх барих хурал хэмээх ардын төлөөлөгчдийн байгууллагын систем тогтжээ”¹⁴¹ хэмээн дүгнэсэн байдаг.

Эл дүрмээр сонгуулийн үндсэн дээр төрийн болон орон нутгийн нэгдмэл тогтолцоо бий болгох зарчим, журмыг тогтоож, дүрмийн нэгдүгээр зүйлд “... арван гэрээс дээш баг, сум, хошуу, аймаг, улсын засгийн газар хүртэл тус, тусын ардын төлөөлөгчдийг сонгон хуралдуулж, дэс дараалан **хурал** байгуулан, элдэв хэрэг зүйлийг шүүмжлэн хэлэлцүүлж, олонхийн саналаар таслан тогтоож, ардын эрхийг

¹³⁵ Санждорж.М. БНМАУ-ын засаг захиргааны зохион байгуулалт тогтон хөгжсөн үе. Ардын төр. 1970.№3 тал 36

¹³⁶ Даваахүү. Д. АДХ бол жинхэнэ ардын төрийн байгуулал мөн. Үнэн. 1975.05.23.№122 (12795)

¹³⁷ Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд. УБ., 1954 тал 60-65

¹³⁸ Мөн тэнд тал 45-60

¹³⁹ Мөн тэнд тал 66-80

¹⁴⁰ Сономдавга.Ц. БНМАУ-ын Орон нутгийн засаг захиргааны хуваарьт гарсан өөрчлөлтүүд.УБ.1967.тал

¹⁴¹ М.Санждорж. Ардын төрийн түүх. УБ.1974. тал 116

эрхэмлэн хүндэтгэвэл зохино"¹⁴² хэмээж гуравдугаар зүйлд "... хурлын төлөөлөгчдийг сонгоход цөм эрхбиш ард олны зовлон зүдгүүрийг нэвтэрхий мэдэх олны тусыг бодох бөгөөд цэвэр, шударга, чадвал бичиг үсэгт боловсронгуй, өөр, өөрийн оролдсон явдлыг магадаар бүтээн чадах хүнийг сонговол зохино"¹⁴³ хэмээн зааснаар төр болоод ард түмнийхээ төлөө гэсэн чин шударга, хүнийг олж сонгохыг заасан төдийгүй цааш нь төрийн өмнө хүлээх хариуцлагыг тодорхойлж өгсөнөөрөө давуу талтай юм.

1922 оны IX сарын 20-нд Засгийн газрын төлөөлөгчдийн дүрэм баталжээ. Уг дүрмийн гуравдугаар зүйлд: "Төлөөлөгчдийг сонгон томилоход засгийн бодлогыг гүйцэдээр ухуулан нэвтрүүлж чадах, уул газар орны эв суртлыг боловсон мэдэх, олны санаанд үнэхээр нийлүүлэн чадах, эрдэм үзэл тэнцэх хүмүүсийг эрхлэх газрын хуралд хэлэлцэн сонгон томилно. Төлөөлөгч суулгавал зохих газрын олон нийтээр уул харъяат газар оронд төлөөлөгч болж болох хүнийг урьдаас батлан гарчих нь болбоос мөн ч хянан сонгоход оруулж болно"¹⁴⁴ гэж заажээ. Хэдийгээр сонгох, сонгогдох эрхийн тухай акт биш ч гэсэн засгийн газрын төлөөлөгчөөр ямар хүнийг сонгох вэ гэсэн шалгуурыг зааж өгсөн анхны эрх зүйн баримт бичиг мөн хэмээн үзэх үндэстэй юм.

Мөн энэ үед сонгуулийн анхны үндсэн зарчим, журмыг тогтоосон байх юм. Арван гэрийн хурал нь эрх бүрийн төлөөлөгчдөөс бусад шатны хурлууд нь доод шатны хурлаас сонгогдсон төлөөлөгчдөөс бүрдэж байв. Үүнээс үзэхэд орон нутгийн засаг захиргааны анхны сонгууль нь олон шаттай байжээ.

1924 оны Улсын анхдугаар их хуралаар баталсан үндсэн хуулийн IV бүлэг "Сонгох сонгогдох эрхийн тухай" бүлгийн 34-р зүйлд "Улсын их, бага хурал ба нутгийн хурлуудад төлөөлөгчдийг сонгох ба мөн төлөөлөгчдөд сонгогдох эрхийг эдэлбээс зохих тус улсын харъяат эр, эм ялгаваргүй хэн боловч сонголт үйлдэх өдөр 18 нас хүрсэн нь:

Нэг: Өөрийн хүчийг үнэлэх буюу хувийн аж ахуй хийж амьдрагчид

Хоёр: Ардын хувьсгалт цэрэг болно"¹⁴⁵ хэмээжээ. Ийнхүү сонгох, сонгогдох эрхийг хуульчлан зааж өгсөн нь сонгуулийн үзэл санааны хөгжлийн шинэ үе шат болжээ.

Ийнхүү Монголын түүхэнд анх удаа орон нутгийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагыг байгуулах төрийн сонгуулийг хуульчлан тогтоосон бөгөөд мөнхүү сонгох, сонгогдох эрхийг хуульчлан заасан ч тухайн нийгмийн онцлогоос шалтгаалан зарим иргэдийн эрхийг хассан юм. Үүнд:

IV бүлэг 35-р зүйлд: Аливаа хурлын төлөөлөгчдийг сонгох ба мөн төлөөлөгчдөд сонгогдох эрхгүй хүмүүс нь:

Нэг: Ямагт ашгийг эрхэмлэж бусдыг зарж мөлжин амьдрагчид

Хоёр: Ямагт бусдыг хөлслөн зарах ба хөрөнгө орлого зэргийн үржлээр амьдрагч жинхэнэ худалдааны ба мөнгө хүүлэгчид

Гурав: Урьдын ван гүн ба хутагт хувилгаан жич орон хийдэд үргэлжид суух санваартан лам нар

Дөрөв: Солиорсон ба ухаан эвдэрсэн бөгөөд зохих газраас шинжлэн батлагдсан

Тав: Эд хичээх зэргээр нэрийг гутаах явдал үйлдэж зарга шийтгэх газраас ял шийтгэгдсэн зэрэг болно"¹⁴⁶ хэмээн зааснаас үзэхэд ард иргэд анх удаа сонгох,

¹⁴² Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд. УБ., 1954 тал 46

¹⁴³ Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд. УБ., 1954 тал 46-47

¹⁴⁴ Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд. УБ., 1954 тал 42

¹⁴⁵ Монгол улсын үндсэн хууль. УБ. Монгол улсын 14 он тал 31

сонгогдох эрхтэй болсон хэдий ч хамжлагт ёсыг халсантай холбоотой сонгуулийн эрхийг лам нар, язгууртан ноёдод өгөөгүй нь юм.

1949 онд IX их хурлаар үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, 80-р зүйлд заахдаа " **Хөдөлмөрчдийн депутатын** бүх хурал, үүнд БНМАУ-ын их хурал аймаг, сум, баг, хот, хороо, хорины хөдөлмөрчдийн депутатын хурлуудад депутатыг сонгохдоо нийт, шууд, тэгш, сонгуулийн эрхийг үндэслэж, сонгогчид саналаа нууцаар гаргаж гүйцэтгэнэ" гэжээ.

Ийнхүү сонгуулийн систем, түүний үндсэн зарчим, хууль эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалт, техник үйл явц нь өөрчлөгдсөн хэдий ч үнэн чанартаа зөвхөн хэлбэрийн шинэтгэл болсон бөгөөд дээрээс зохион байгуулсан, үзэл суртлаар халхавч хийсэн өөрчлөлт байв.

Үүнийг Б.Пүрэв "БНМАУ-ын сонгуулийн хамгийн **ардчилсан** систем тогтоосон цөөн орны нэг" ¹⁴⁷ хэмээн үзсэн байна. Үнэндээ бол дээрээс нэрсийг нь гаргаж, 99-100 % ийн санал хураалтаар сонгодог "томилолтын" депутатуудыг ард иргэд сонгож байсан нь ардчилсан систем гэж үзэхэд учир дутагдалтай байв.

1952 онд "БНМАУ-ын аймаг, хот, сум, хороо, баг, хорины ХДХ-ын сонгуулийн тухай дүрэм" батлагдан тэдгээр хуулийн актуудад сонгуулийн бүхий л үйл явц, харилцааг журамлан зохицуулах заалтууд орсон. Энэ үеийн дэвшил нь саналаа нууцаар гаргах болсон явдал байлаа. Үүний үндсэн дээр аймаг, сум, баг, хороо, хорины ХДХ-ын сонгууль 1952-1960 он хүртэл 1952, 1954, 1956, 1959 онуудад 4 удаа явагдсан бөгөөд хууль эрхийн зохицуулалтын дүрмийг хэд хэдэн удаа шинэчилсэн.

1954 оны II дахь сонгуулиас Улаанбаатар хотын Хөдөлмөрчдийн Депутатын Хурлын Гүйцэтгэх Захиргааны шийдвэрээр тойргуудыг байгуулжээ. Нийт 13 хороон дээр 166 тойрог байгуулан, сонгуулийн бэлтгэл ажлыг хийжээ. Сонгуулийн тойрог зарим хороон дээр 7 байгуулагдсан байхад зарим хороон дээр 18 тойрог байгаа нь хүн амын нягтшил нөлөөлж байв. Орон нутгийн сонгууль өнөөгийн ойлголтоор мажоритар (энгийн олонхийн саналаар сонгох) системийг баримталж байсан хэмээн үзэх бүрэн үндэстэй юм.

1952 онд Орон нутгийн АДХ-ын анхны сонгууль болж, сонгуулийн комисст 62352 сонгогч оролцож, 18 аймаг, 1 хот, 340 сум, 12 хороо, 2712 баг, оролцсон сонгогчдын 99.89 % нь саналаа өгч, 32705 депутатын 12.2% нь ажилчин, сэхээтэн, 88.3% нь нэгдлийн гишүүд байсан бөгөөд 23.1% ийг нь эмэгтэйчүүд ¹⁴⁸ эзэлж байв.

1975 оны XI удаагийн сонгуулийн материалыг X дахь удаагийн сонгуулийн материалтай харьцуулан үзэхүйд: XI дэх удаагийн сонгуулиар 14415 тойрог байсны дотор аймаг, хотын хурлын тойрог 1981, районы хурлын тойрог 422, сумынх 9646, хорооных 853, орон нутгийн хурлын тойрог 1513 ¹⁴⁹ байсан бол 10 дахь удаагийхтай харьцуулвал аймгийн хуралд 137, районы хуралд 13, хорооны хуралд 126, орон нутгийн хотын хуралд 71 тойрог нэмэгдсэн байна. Харин хэд хэдэн сумыг татан буулгасан учир сумын хурлын тойрог 149 өөр буурсан.

Орон нутгийн хурлын дүнгээр 198 тойрог, сонгуулийн 17 хэсэг нэмэгдэж, 1545 хэсэг байгуулагдсан байна. ¹⁵⁰ Энэ нь 1954 оноос эхлэн сум багуудыг нэгтгэж, цомхтгож байсантай холбоотой мөн 1956-8-1 ний өдрийн АИХТ-ийн зарлигаар сум,

¹⁴⁶ Монгол улсын үндсэн хууль. УБ.Монгол улсын 14 он тал 32

¹⁴⁷ Б.Пүрэв. Социалист төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагын тухай ленинч сургаал БНМАУ-д хэрэгжсэн нь. УБ.1981 тал 51

¹⁴⁸ УТА. Хөмрөг-11. Д №1. ХН-1529 Х-125

¹⁴⁹ УТА. Хөмрөг-11. Д №2. ХН.537. Х-147 тал 4

¹⁵⁰ УТА.Хөмрөг-11. Д №2.ХН-537 тал 3

баг, хороодыг татан буулгаж, 1959 оны 8 сарын 5 ны өдрийн зарлигаар шинээр сум байгуулж, багуудыг татан буулгаж байсантай холбоотойгоор 1952 оны анхны сонгуулийн тойрогтой харьцуулвал асар их өөрчлөлт орсон байна.

Сонгуулийн нэрсийн жагсаалтанд 1967 оны VIII дахь удаагийн сонгуульд 563000 сонгогч бичигдсэн байсан бол 1975 оны XI дэх удаагийн сонгуулийн нэрсийн жагсаалтанд 655347¹⁵¹ сонгогч бичигдэн тоо нь өсчээ. Мөн VIII дахь удаагийн сонгуульд 13751 депутат сонгогдож байсан бол XII дахь удаагийн сонгуульд 15117¹⁵² депутат сонгогдсон байна. Харин сонгогдсон депутатын 20.6%-28.9% ийг эмэгтэйчүүд эзэлж байв. Энэ дүнг 1952 онтой харьцуулахад эмэгтэйчүүдийн эзлэх хувь тодорхой хэмжээгээр нэмэгдэж байжээ. Ер нь 15 удаагийн орон нутгийн хурлын сонгуулийн дүнг нэгтгэн гаргахад өнөөгийн улс төрчдийн маргаантай асуудлын нэг болох жендерийн харьцаа харагддаг бөгөөд 18-29.5% эмэгтэйчүүд сонгогдож байсан юм.

Үүнээс гадна хүн амын бүтцийн өөрчлөлт депутатын бүрэлдхүүнд нөлөөлж байсан нь ажиглагдлаа. 1952 оны сонгуулиар депутатуудын 88.3% нь малчин, 10.6% нь сэхээтэн, 1.6% нь ажилчин¹⁵³ байсан бол 1984 оны 14 дэх удаагийн сонгуулийн депутатуудын 3317 буюу 21.2% ажилчин, 4837 буюу 30.9% нь ХАА-н нэгдлийн гишүүд, 7511 нь буюу 47.9% нь албан хаагчид сэхээтэнүүд сонгогджээ. Үүнээс үзэхүйд 80 аас дээш хувь нь малчид сонгогддог байсан бол 50 орчим хувь нь албан хаагчид, сэхээтэн сонгогдсон нь МАА орноос ХАА-н орон болсонтой холбоотой төдийгүй 1940-1950 оны үед их, дээд сургуулиуд байгуулагдан, сэхээтэн, албан хаагчдын шинэ давхараа бий болсонтой холбож тайлбарлаж болох юм.

Ийнхүү 1951 оноос эхлэн явуулсан сонгуулийн тогтолцоо нь өмнөх үеэ бодвол дэвшилттэй байсан төдийгүй АДХ-ын сонгуульд нийт иргэдийн 99,67-99,99% нь оролцож ирсэнийг ард түмний эрх агшийг илэрхийлсэн жинхэнэ "ардчилсан сонгууль" болж байсан гэж нэг талаас үзэж болох ч энэ нь хэрэг дээрээ хэлбэрийн төдий байсан юм. Үүнийг ч гэсэн эрдэмтэд судлаачид хүлээн зөвшөөрч байв. Үүнд:

"...Захиран тушаах хүнд суртлын тогтолцооны жилүүдэд депутатад нэр дэвшүүлэлэхээс эхлээд сонгууль явуулах бүхий л үйл ажиллагаанд сонгуулийн ардчилал ёс төдий болж, сонгуулийг дээрээс журамлан зааварлаж, депутат нарын нийгмийн бүрэлдхүүнийг урьдчилан тогтоож, "заавал сонгогдох ёстой" дарга, сайд нарыг тухайн үеийн тойргуудад хувиарлан нэрээр нь тулгадаг байсан учраас сонгогчид жинхэнэ сонгоё гэсэн хүнээ сонгож чадахгүй харин дээрээс оноосон нэг л хүний төлөө саналаа өгөх болсон¹⁵⁴ хэмээгээд тухайн үеийн сонгуулийг чирэгдэл ихтэй, нүсэр болж, хэт хэлбэрдэл, гажуудалд орж, гол агуулга болсон өрсөлдүүлэн, шалгаруулах ёс алдагдсаныг хүлээн зөвшөөрсөн юм.

Мөн ... "бүх шатны хурлын сонгууль нь чөлөөт сонголтгүй, намын удирдах байгууллагаас нэр заан дэвшүүлсэн хүмүүс буюу нэг ёсны сонгууль нэртэй "томилолтын" депутатууд байлаа. Тэр үед сонгуульд хэний нэр дэвшүүлэх вэ, хэн сонгогдох вэ, сонгогчид хэдэн хувиар санал өгөх вэ эд бүгдийг эрх баригч намаас урьдчилан боловсруулсан сценарийн (дэг журмын) дагуу явуулдаг нэг ёсны "жүжиг" байлаа¹⁵⁵ хэмээн үзсэн байдаг ч энэ үеийн сонгуулийн систем нь Монгол оронд

¹⁵¹ Мөн тэнд

¹⁵² УТА. Хөмрөг-11.Д №2, ХН-738. Х-201 тал 165

¹⁵³ УТА.Ф-11.Д№1.ХН-1529.125-р тал

¹⁵⁴ Болдбаатар.Ж.Лүндээжанцан.Д. Монголын төр эрх зүйн түүхэн уламжлал. УБ. 2006 тал

342

¹⁵⁵ Улс төрийн шинжлэх ухаан. УБ., 244

тогтож байсан улс төрийн дэглэм, нэг намын засаглал, үзэл сурталжсан байдал, ЗХУ-ын хяналт, нөлөөгөөр тодорхойлогдож байсан бөгөөд **ардчилсан** сонгууль явуулах боломжгүй байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Ийнхүү Монгол дахь орон нутгийн хурлын сонгуулийн түүх хэрхэн бүрэлдсэнийг авч үзэхэд:

1. Анхны төрт улс байгуулагдсан МЭӨ III зууны үеэс эхлэн Монголын түүхийн эрт, дунд үед сонгуулийн тогтолцооны талаар ямар нэгэн баримт, эх сурвалж байхгүй хэдий ч 1921 оны хувьсгал хүртэл төрийн албанд тохоон томилох хүнийг шилж сонгох, хааныг өргөмжлөх тодорхой нэгэн шалгуур байсан төдийгүй энэ нь сонгуулийн зарим бүрдэл болж байсныг үгүйсгэх аргагүй юм. Түүнчлэн Их Монгол улсын үед хааныг эс оролцуулах аваас түмт, мянгатын ноёдыг сонгохдоо угсаа гарвал гэхээсээ илүүтэйгээр авъяас, чадвар, эр зориг, чин шударгуу ёсыг гол үзэл баримтлалаа болгож байсан.

2. 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын дараа төлөвшөн тогтсон Монгол дахь орон нутгийн хурлын сонгуулийн тогтолцоо нь өнөөгийн орон нутгийн ИТХ-ын "ардчилсан" сонгуулийн хөгжлийн эх үүсвэр байсан бөгөөд 1924 оны үндсэн хуулинд зарим талаараа сонгох, сонгогдох эрх нь хязгаарлагдмал байсан ч цаашид гүнзгийрэн хөгжих, эрх зүйн үндэс болж чадсан юм.

3. 1920 оноос эрх зүйн анхны баримт бичигүүдэд тусгагдан, 1924 оны үндсэн хуульд баталгаажсанаар төрийг удирдах хэрэгт ард иргэдийг өргөнөөр оролцуулах болсон нь социалист нийгмийн шалгуурт нийцсэн ойлголт байсан хэдий ч Монголын улс төрийн түүхэнд өнөөгийн сонгуулийн тогтолцоо анх тавигдсан хэмээн үзэх бүрэн үндэстэй юм.

4. 1921-1990 он хүртэл нэг намын тогтолцооны үед орон нутгийн хурлын сонгууль төдийгүй бүх шатны хурлын сонгууль нь чөлөөт сонголтгүй, намын удирдах байгууллагаас нэр заан дэвшүүлсэн хүмүүс, өөрөөр хэлбэл "томилолтын" депутатууд сонгогдож байсан нь нэг талаасаа тухайн үеийн ойлголтоор нийгмийн анги бүлгийн төлөөллийг зохицуулж байгаагаараа эерэг талтай байсан боловч нөгөө талаасаа ямар ч өрсөлдөөнгүй, сонгогчид сонголтгүй байснаараа сөрөг талтай байв.

5. 1951 оноос бүх нийтийн, тэгш, шууд болон санал нууцаар хураах зарчмын үндсэн дээр сонгууль явуулах болсон хэдий ч ардчилсан шинжтэй болж чадаагүй юм. Гэхдээ энэ нь ардчилсан бус аливаа улс орны нийтлэг дүр зураг байсан.

6. Дээд шатны сонгууль нь дарга, сайд нарын хүрээнд явагдаж "томилолтын" депутатууд сонгогдож байсан хэдий ч орон нутгийн хурлын сонгуулийн эерэг тал нь тухайн орон нутагтаа шилдэг, тэргүүний малчид, ажилчин албан хаагчид, сэхээтэнүүд сонгогдож байсныг өнөөгийн 21 аймаг болон сумуудаас авсан судалгаанаас харж болох юм.

Abstract

(Developmental issues of local election of Mongolia)

The research covers the history of local administrative organizations so called public assembly, labourer's public assembly, labour representative's assembly, public representative's assembly and historical development of their structure and legal status. The main of our study is an election system and how it was formed of and developed. During the People's Revolution of 1921, election system was reflected in documents. And it was enacted by constitution of Mongolia in 1924 and had been developed until 1990.